

СЭРГЭЭН ЗАСАХ АМРАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.12.31

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 31/21 тоот удирдамжийн хүрээнд Сэргээн засах амралтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ын аудитор А.Мөнх-Эрдэнэ, хяналт-шинжилгээ, үнэлгээний ахлах мэргэжилтэн М.Мөнгөншагай, аудитор Т.Саранчимэг, О.Сэндэр санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ж.Нямдэлгэр, Б.Болормаа, Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сэргээн засах амралтын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацааны касс, харилцах дансны үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бүрдүүлэлт, захиргаа, дотоод хяналтын үйл ажиллагаа, мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, бараа материалын бүртгэл зэргийг нягталж шалгахад гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Бүтцээр шилжиж ирсэн хоол үйлдвэрлэлийн хэсэгт үйлдвэрлэгдэж байгаа хоол, хүнсний “Технологийн карт”-ыг шинэчилж батлуулаагүй. Шинээр үйлдвэрлэж эхэлсэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний “Технологийн карт”-ыг боловсруулаагүй.

Сэргээн засах амралтын хоол үйлдвэрлэлээс олж байгаа орлого нь тухайн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний өртөг, зардалтай уялдуулж борлуулалтын үнийг тогтоогоогүйгээс шууд материал, шууд хөдөлмөрийн зардал буюу үндсэн зардлыг нөхөж чадахгүй байна.

СЗА-ын Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг шалгахад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.-д заасныг зөрчиж, баримтгүйгээр гүйлгээ хийсэн, анхан шатны баримтын эх хувийг хавсаргаагүй зэрэг зөрчил илэрсэн.

ИНЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/901 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3.2-т заасан Бараа материалын бүртгэлийн горимыг хангалттай хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн, санхүүгийн програмд бараа материалын бүлгийг алдаатай сонгосон.

Ажилласан өдөр болон ХЧТАлдсаны тэтгэмжийн хоногийг давхардуулснаар 3 ажилтанд цалин хөлс илүү бодож олгосон.

Дэлгүүрийн удирдлагын системийг бүрэн ашиглахгүй байгаагаас бүртгэл хөтлөлт удаашралтай, хяналт тавихад хүндрэлтэй байдал арилаагүй.

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроох, буруу, дутуу мэдээлж байсан дутагдлаа залруулан ажиллаж байгаа хэдий ч нягтлан бодогчийн хайнга байдлаас 2 гүйлгээг мэдээлээгүй, 2 гүйлгээг буруу мэдээлсэн.

Сэргээн засах амралтын 2021 оны худалдан авах ажиллагааг шалгахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасан тендерийн хавтаст хэргийг хангалтгүй бүрдүүлсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм” -ийн 7.4-т хоол бэлэн болсноос хойш борлуулах хугацааг тодорхой зааж өгсөн боловч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөөгүй.

Өдөр тутмын хоол үйлдвэрлэлийн төлөвлөгөөг тодорхой судалгаанд үндэслэж хийдэггүйтэй холбоотой байна.

Буянт-Ухаа ОУНБ дахь зоогийн газрын бэлэн мөнгөний орлогыг тухай бүр нягтлан бодох бүртгэлийн програмд гүйлгээг хийгээгүй.

ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажилтнууд ИНЕГ-ын даргын 2019 оны А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ын дагуу нэг, хоёр, гурав дахь шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

2021 оны ХАБЭА-н чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийт 16 ажлын 11 ажил нь гүйцэтгэл хангалттай, 5 ажил нь огт хэрэгжээгүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1 зөвлөмж, Сэргээн засах амралтад 15 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА